# БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТОГТООЛ

2025 оны 12 сарын 16 өдөр    Дугаар А/22    Улаанбаатар хот

Засаг даргын 2024-2028 оны
үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний
биелэлтийг үнэлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VI хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Багахангай дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцээд жилийн эцсийн байдлаар 90,7 хувийн хэрэгжилттэй, “Үр дүнтэй” гэж үнэлсүгэй.

2.Багахангай дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА    Ф.МӨНХГЭРЭЛ

1225010078

# БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 12 — Багахангай дүүрэг

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | | 7 | 8 | 9 | | | 10 | 11 |
| 1.БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО<br>Бүсчилсэн хөгжил, хот байгуулалт | | | | | | | | | | | | | |
| 1.1 Хот байгуулалт холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан дүүргийн хөгжлийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ. | | | | | | | | | | | | | |
| 1 | 1.1.1 | "Багахангай 2040 хөгжлийн хөтөлбөр" бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллана. | ЗДТГ | - | - | - | Баримт бичгийн хэрэгжилтийн явц | хувь | 50 | 30 | - | Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь судалгаа, зөвлөх үйлчилгээний "Эс Ай Си Эй" ХХК-иар "Багахангай 2040 хөгжлийн хөтөлбөр" бодлогын баримт бичгийг гүйцэтгүүлж, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXV хуралдаанаар хэлэлцүүлэн, 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын А/06 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Дээрх тогтоолын 2.3 дахь хэсэгт тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулахаар тусгагдсаны дагуу 2026 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийг нэгтгэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна.<br>"Багахангай 2040 хөгжлийн хөтөлбөр" бодлогын баримт бичгийг 2025-2030, 2031-2040 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 116 арга хэмжээтэйгээр төлөвлөсөн.<br>Хэрэгжилтийн хувь 60 | 60 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | 1.1.2 | Багахангай хотыг хөгжүүлэх ТЭЗҮ, үзэл баримтлал, ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна. | Хот байгуулалт, хотын стандартын газар | Улсын төсөв | - | - | Суурь баримт бичиг боловсруулах ажлын явц | хувь | 100 | 70 | 2,000.0 | Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, нийслэлээс баримталж буй хөгжлийн бодлогын хүрээнд тус дүүрэг нь Багануур, Налайх дүүргүүдийн хамт улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотод шилжихтэй холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс 2.000,0 төгрөгийн төсөвт өртгийг шийдвэрлэж, дүүргийн нутаг дэвсгэрийг бүрэн хамруулан, ТЭЗҮ хийх тендерийг зарлаж, гүйцэтгэгчээр Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш, судлаачдын баг шалгарч судалгааны ажлыг эхлүүлээд байна.<br>Дээрх судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх хүрээнд дүүргийн Засаг даргын 2025 оны А/174 дугаар захирамжаар 17 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг байгуулж, гишүүдэд холбогдох чиглэлийг өгөхөөр ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, гүйцэтгэгчээс ирүүлсэн судалгааны ажилд шаардлагатай баримт материалын жагсаалтын талаар танилцуулан холбогдох мэдээллийг хүргүүлсэн.<br>Хэрэгжилтийн хувь 70 | 70 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | | Багахангай хотыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. | Хот байгуулалт, хотын стандартын газар | хувь | - | - | Бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын явц | хувь | 10 | 10 | - | Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч Г.Батсайхан, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэр нар Багахангай дүүргийн иргэд, сонгогчидтой уулзах уулзалтыг 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Соёлын ордонд зохион байгууллаа.<br>Уулзалтаар "Улаанбаатар хот 2040" хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг танилцуулж, Багахангай дүүргийг дагуул хот болгон үйлдвэр технологийн чиглэлээр тулхүү хөгжүүлэх талаар мэдээлж байв.<br>Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд дүүргийн төвийн 3,000.0 га нутаг дэвсгэрт хийгдсэн хэсэгчилсэн төлөвлөлтийг нэмэгдүүлж 5,739.2 га газарт хийхээр тусгагдаад байна.<br>Хэрэгжилтийн хувь 10 | 100 |
| Дулаан, цахилгаан хангамж, дэд бүтэц, бүтээн байгуулалт | | | | | | | | | | | | | |
| 1.2.Дэд бүтцийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэн, найдвартай байдлыг хангаж, иргэдийн амьдрах орчныг сайжруулна. | | | | | | | | | | | | | |
| 4 | 1.2.1 | Дүүргийн 2 дугаар хороонд 48 айлын орон сууцны барилгыг шинээр барьж, ашиглалтад оруулна. | Гүйцэтгэгч "Юнайтэд Хэрэйд" ХХК | Хувийн хэвшлийн хөрөнгө | 2024 | 30 | Барилгын ажлын явц | хувь | 100 | 100 | - | Дүүргийн 2 дугаар хороонд нийтийн зориулалттай орон сууцны 3 төсөл хэрэгжиж байгаа бөгөөд 48 айлын орон сууц барих ажлыг "Юнайтед хэрэйд" ХХК гүйцэтгэж, 2025 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулав.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 5 | 1.2.1 | Дүүргийн 2 дугаар хороонд НОСК-ийн санхүүжилтээр 8 айлын орон сууцыг барина. | Гүйцэтгэгч "Жавхлан хүслэн" ХХК | НОСК-ийн санхүүжилт | 2024 | 30 | Барилгын ажлын явц | хувь | 100 | 100 | - | НОСК-ийн санхүүжилтээр 2 дугаар хороонд 8 айлын орон сууц барих ажлыг "Жавхлан хүслэн" ХХК гүйцэтгэж, 2025 онд ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 6 | 1.2.2 | Нуур, Замчин гэр хорооллын "Дэд бүтцийн төв"-ийн гадна инженерийн хангамж, шугамын ажлыг үргэлжлүүлнэ. | Гүйцэтгэгч "ГЦЦЭ" ХХК | Улсын төсөв | 2024 | 40 | Ажлын гүйцэтгэл | хувь | 70 | 70 | 4,1 тэрбум | "Дэд бүтцийн төв"-ийн гадна инженерийн хангамж, шугамын ажлын гүйцэтгэгчээр 2024 оноос "ГЦЦЭ" ХХК ажиллаж, 2025 онд 3460 метр цэвэр усны, хэрэглээний халуун усны, халаалтын, бохир усны, дулааны зэрэг 5 шугамын далд ажил, 6,5 км бохир усны шугам, 400 метр цахилгаан кабелийн ажил хийгдээд байна.<br>"Дэд бүтцийн төв" нь 2 талын цахилгаан дамжуулах тэжээлтэй байх бөгөөд Багануур дүүргээс агаараар цахилгаан дамжуулах шугамыг татах, дэд бүтцийн төвийн зуухны барилгын ажил, бохир ус соруулах насос, тоног төхөөрөмж зэрэг ажлуудыг ирэх онд хийхээр төлөвлөөд байна.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 7 | 1.2.3 | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн явган хүний замыг засварлана. | Багахангай тохижилт ОНӨААТҮГ | Дүүргийн төсөв | 2024 | 350 | Засварласан явган зам талбай | $м^2$ | 300 | 300 | 20,0 | Тус онд 1, 2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн дараах байршлуудад явган хүний замын эвдрэл гэмтлийг тухай бүр засварлан ажилласан. Үүнд:<br>- "Эко тогоо"-оос модон гүүр хүртэлх явган хүний замын эвдрэл гэмтэл,<br>- 1 дүгээр хорооны байрнаас Засаг даргын Тамгын газар чиглэлийн явган замын эвдрэл гэмтэл,<br>- 1 дүгээр хорооны 1-р байрны урд талын явган хүний замын эвдрэл гэмтэл,<br>- НЕБ-ын 91 дүгээр сургуулиас Илч-Орд ОНӨААТҮГ хүртэлх явган хүний замын засвар үйлчилгээ зэрэг нийт 300$м^2$ талбайд засвар үйлчилгээ хийв.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 1.2.4 | Саалийн толгой, Хадат шинэ суурьшлын бүсийн цахилгаан эрчим хүчний шугам сүлжээг өргөтгөх ажлын хүрээнд зураг, төсөв боловсруулна. | "Перфект солюшн энд инженеринг" ХХК | Дүүргийн төсөв | - | - | Зураг төсвийн ажлын гүйцэтгэл | хувь | 100 | 90 | 24,0 | Тус ажлын үнэлгээний хороог дүүргийн Засаг даргын 2025 оны А/18 дугаар захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав.<br>Зураг төсвийг гүйцэтгэгчээр "Перфект солюшн энд инженеринг" ХХК шалгарч, 24,0 сая төгрөгөөр гүйцэтгэв.<br>Хэрэгжилтийн хувь 90 | 100 |
| 9 | 1.2.5 | Дүүргийн гол, туслах авто замын зорчих хэсгийн эвдрэл хагарлыг нөхөх ажлыг гүйцэтгэнэ. | "Эко эвсэг зам" ХХК, "Тэгс ирээдүйн зам" ХХК | Нийслэлийн төсөв, Замын сан | - | - | Ажлын тоо, талбайн хэмжээ | км | 3 | 3,5 | 2,5 тэрбум | Дүүргийн хэмжээнд 2025 онд авто замын засвар, арчлалтын 3 ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>- 2 дугаар хорооны цогцолбор байрнаас хороо хоорондын авто зам хүртэлх зам засвар, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчээр "Эко эвсэг зам" ХХК шалгарч, 1,9 км замын засварын ажлыг 1,400.0 төгрөгөөр гүйцэтгэв.<br>- Хороо хоорондын авто зам шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчээр гүйцэтгэгчээр "Тэгс ирээдүйн зам" ХХК шалгарч, 1,6 км авто зам засварын ажлыг 1,000.0 төгрөгөөр гүйцэтгэв.<br>- Дүүргийн авто зам засварын ажлуудыг "Тэгс ирээдүйн зам" ХХК 400м авто замыг засварлан, 100м авто замын хагарлын гагнаасыг дүүргийн төсвийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэв.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 10 | 1.2.8 | Өндөртолгой хотхоны хойд жигүүрийн халаалт, хэрэглээний шугамыг шинэчилнэ. | Гүйцэтгэгч "Бэсүжин констракшн" ХХК | Нийслэлийн төсөв | - | - | Шинэчлэх шугамын урт | м | 280 | 280 | 519,9 | Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/726 дугаар захирамжаар тус ажлын эрх дүүрэгт шилжин ирсний дагуу дүүргийн Засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулагдаж, тендерийг зарлан гүйцэтгэгчээр "Бэсүжин констракшн" ХХК шалгарав.<br>Тус ажлын төсөвт өртөг 519,9 сая төгрөг бөгөөд 280 метр урттай, 4 хос шугамын ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрүүдийн хооронд гүйцэтгэв.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 11 | 1.2.10 | Дүүргийн 1 дүгээр хорооны нийтийн зориулалттай орон сууцны 2, 6 дугаар байрны хэрэглээний халуун ус болон цэвэр усны босоо шугамыг солино. | "Цаст хайрхан констракшн" ХХК | ОНХС-гийн хөрөнгө | - | - | Шугам шинэчлэх орон сууц | тоо | 2 | 2 | 365,2 | Дүүргийн 1 дүгээр хорооны нийтийн зориулалттай орон сууцны 2, 6 дугаар байрны хэрэглээний халуун ус болон цэвэр усны босоо шугам солих ажлын гүйцэтгэгчээр "Цаст Хайрхан констракшн" ХХК шалгарч, 365,2 сая төгрөгийн төсөвт өртгөөр ажлыг гүйцэтгэв.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 12 | 1.2.11 | "Илч-Орд" ОНӨААТҮГ-ын хэрэглээний халуун ус, халаалтын зуухны яндангуудад утааны шүүлтүүр суурилуулна. | Гүйцэтгэгч "Бэсүжин констракшн" ХХК | Дүүргийн төсөв | - | - | Суурилуулах шүүлтүүр | тоо | 5 | 5 | 135,0 | Дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ-ын халаалтын болон хэрэглээний халуун усны халаалтын зуухны 5 янданд орчны бохирдлыг бууруулах зорилгоор Ф1000, Ф500-ын яндангуудад утааны шүүлтүүр 1,8 мвт хүчин чадалтай зууханд 3 ш шүүлтүүр, 3,5 мвт хүчин чадалтай халаалтын зууханд 1 ш шүүлтүүр, 1 мвт хүчин чадалтай халаалтын зууханд 1 шүүлтүүр суурилуулах ажлыг "Бэсүжин констракшн" ХХК 135,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр нийлүүлж халаалт, хэрэглээний халуун усны зуухнуудад суурилуулав.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| **Газрын харилцаа** | | | | | | | | | | | | | |
| **1.3.Иргэдийн эзэмшиж буй газрыг өмчлүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах бодит нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.** | | | | | | | | | | | | | |
| 13 | 1.3.1 | Дүүргийн тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар олголтыг хуулийн дагуу зохион байгуулна. | ГЗБА | - | 2024 | 330 | Хууль тогтоомжийн дагуу газар эзэмшиж, ашиглан, өмчилсөн иргэн, хуулийн этгээд | тоо | 100 | 204 | - | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/13 дугаар тогтоолоор дүүргийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулсан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолоор дэмжигдэж Газрын тухай хуулийн дагуу 150 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлж, ашиглуулсан. Мөн нийслэлийн Засаг даргын 3 удаагийн захирамжаар 54 иргэний эзэмшиж буй газрыг өмчлүүлсэн.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | 1.3.2 | Газрын дуудлага худалдааг 2 удаа зохион байгуулна. | ГЗБА | - | 2024 | 1 | Зохион байгуулсан дуудлага худалдаа | тоо | 2 | 5 | - | Дүүргийн Засаг даргын захирамжаар 7 байршилд 5 удаа газар эзэмших, ашиглах эрхийн нээлттэй дуудлага худалдааг зарлаж 124,0 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 15 | 1.3.5 | Газрын төлөв байдал, чанарын улсын төлөвлөгөөт хянан баталгааны ажлыг дүүргийн суурин газарт хийнэ. | ГЗБА | - | 2019 | 8000 | Газрын хянан баталгаа хийсэн талбайн хэмжээ | га | 14000 | 14000 | - | Нийслэлийн 2025 оны төсөвт 100,0 сая төгрөгийг тусгуулж "Вектор мэп" ХХК нь дүүргийн нутаг дэвсгэрийг бүрэн хамруулан газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлыг гүйцэтгэн Газар зохион байгуулалт, Геодези зураг зүйн ерөнхий газарт хүлээлгэн өгсөн.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| **2.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО<br>Эрүүл мэнд** | | | | | | | | | | | | | |
| 2.1 Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд эрүүл зөв амьдралын дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ | | | | | | | | | | | | | |
| 16 | 2.1.1 | Эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдын ур чадварыг үе шаттайгаар дээшлүүлж шаардлагатай хүний нөөцөөр хангана. | Эрүүл мэндийн төв | - | 2024 | 144 | Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтан | тоо | 150 | 422 | - | Эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг ур чадварыг дээшлүүлэх 102 удаагийн сургалтад давхардсан тоогоор 422 ажилтан, албан хаагчийг хамруулав. Их эмч 6, сувилагч 1, бичиг хэргийн ажилтан 1 нийт 8 ажилтныг байнгын ажлын байраар хангав. Мэргэжил дээшлүүлэх сургалтад 2 ажилтан суралцаж байгаагаас гадна БНХАУ-ын Хөх хотод зохион байгуулагдсан мэргэжил дээшлүүлэх сургалтад 2 эмч, 1 ажилтан хамрагдав. ЭМЯ, НЭМГ, НЭМҮТ-өөс зохион байгуулсан 69 удаагийн сургалтад давхардсан тоогоор 97 эмч, эмнэлгийн ажилтныг, дотоодын сургалтыг 33 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 325 ажилтан албан хаагчийг хамрууллаа.<br>Эмч, эмнэлгийн ажилтны сул орон тоог нөхөх, | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дүүргийн төсөв | 2024 | 4 | Ажлын байраар хангагдсан эмч, ажилтан | тоо | 4 | 8 | 51,0 | нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл, хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд илүү цаг, баярын цаг, шөнийн цагийн нэмэгдлийг сар бүр, ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн урамшууллыг 60 хүртэлх хувиар тооцон тогтмол олгож байна.<br>Дүүргийн ИТХ-ын 2024 оны А/18 дугаар тогтоолын дагуу ЭМТ-д үндсэн эмчээр ажиллах 6 хүртэлх эмчид орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар олгохоор санхүүжилт олгох гэрээг ЭМТ-тэй байгуулан ажиллаж байна. Уг гэрээний дагуу шалгуур хангасан 6 эмчид 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 25,683,400 төгрөгийн нэмэгдлийг дүүргийн төсвөөс олгоод байна. Төрийн албан хаагчдын орон сууцанд 2 их эмч, 1 сувилагч амьдарч байна.<br>Хэрэгжилтийн хувь 100 | |
| 17 | 2.1.2 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | Эрүүл мэндийн төв | Дүүргийн төсөв | 2024 | 18 | Хангагдсан тоног төхөөрөмж | тоо | 3 | 6 | 63,5 | Эрүүл мэндийн төв 4 нэр төрлийн 6 ширхэг 63,5 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжөөр хангагдав. Лабораторийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор 2025 онд нийт 63,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэв. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 24,278,125 төгрөгийн өртөг бүхий цусны хагас автомат анализаторийг "Иттэл эрүүл мэнд" ХХК, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 39,337,000 төгрөгийн өртөг бүхий биохимийн аппаратыг "Сүвэн Уул" ХХК тус тус нийлүүлээд байна. ЭМЯ-аас гар ЭКГ, хяналтын монитор зэрэг 2 нэр төрлийн 4 ширхэг тоног төхөөрөмжөөр хангав.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 18 | 2.1.3 | Урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамрагддаг иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | Эрүүл мэндийн төв | - | 2024 | 70.1 | Үзлэгт хамрагдсан иргэд | хувь | 70 | 44,9 | - | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолоор дүүргийн Эрүүл мэндийн төв хүн амын тооноос шалтгаалан "Анхан шатны тусламж үйлчилгээ"-рүү шилжсэнтэй холбогдуулан эрт илрүүлэг үзлэгт 0-18 насны хүүхдийг хамруулах боломжтой байгаа ба насанд хүрэгчдэд үзлэг хийх эрх нээлгэх саналыг ЭМДЕГ-т хүргүүлэв. ЭМЯ-аас эрт илрүүлгийн үзлэгийн улсын хэмжээнд зогсоов. Тайлангийн хугацаанд ЭМТөвд 37116 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 16679 буюу 44,9% байна.<br>Хэрэгжилтийн хувь 64 | 64 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 19 | 2.1.4 | Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | Эрүүл мэндийн төв | Дүүргийн төсөв | - | - | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 4 | 6 | 2,5 | Тайлангийн хугацаанд эх нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй. Жирэмсний хяналтад 53 жирэмсэн эмэгтэй орсон ба эхний 3 сартай хяналт 44 буюу 83 хувьтай байна. ЭМТ нь жирэмсний хяналт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор эмэгтэйчүүдийн их эмч, эх баригч бага эмч нийт 2 орон тоотой тусламж үйлчилгээг үзүүлэв. Мөн хүүхдийн нарийн мэргэжлийн эмчийг 10 дугаар сараас авч ажиллуулж байна. Жирэмсэн эхчүүдэд 4 удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 56 жирэмсэн эмэгтэй хамрагдав. Төрөх насны 15-45 насны эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж урьдчилан сэргийлэх үзлэгт 152 эмэгтэйг хамруулав. Зорилтот бүлгийн 138 эмэгтэйчүүдээс 87 эмэгтэйг жирэмснээс хамгаалах эм, тариа, суулгацад хамруулснаар эрсдэлт бүлгийн иргэдийн 63 хувийг жирэмснээс сэргийлэх аргад суралцуулав.<br>БШУС, Эрүүл мэндийн сайд, ХНХС-ын 2023 оны А/23, А/80, А/189 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ (2023-2026)", "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 92 хувьтай байна. KOIKA олон улсын байгууллагатай хамтран 4-12 дугаар ангийн 340 сурагчдыг чихний сонсгол, чих хамар хоолойн үзлэгт хамруулж зөвлөгөө мэдээлэл өгөв.<br>ЭМТ-өөс эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахаар ирсэн 871 хүүхдэд зөвлөгөөг өгөв.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | 2.1.5 | Явуулын үйлчилгээнд цахим технологийн хэрэглээг нэмэгдүүлнэ. | Эрүүл мэндийн төв | Дүүргийн төсөв | 2024 | 30 | Явуулын үйлчилгээнд хамрагдсан иргэд | тоо | 80 | 129 | 2,0 | 2025 оны 05 дугаар сард Хангай зэрлэгт зохион байгуулагдсан "Иргэн таныг сонсъё" явуулын өдөрлөгөөр 6 төрлийн эрүүл мэндийн үйлчилгээг 58 иргэнд үзүүлэв. Явуулын нэг цонхны үйлчилгээ 2 удаа зохион байгуулагдаж 71 иргэнд 8 төрлийн үйлчилгээ үзүүлсэн байна.<br>Мобайл технологийн явуулын оношилгооны ЭКГ, эхоны аппаратыг түргэн тусламжийн үйлчилгээнд ашиглаж байна.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 21 | 2.1.6 | Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ. | Эрүүл мэндийн төв | - | 2024 | 5 | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 5 | 27 | - | Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран амьдралын зөв дадал олгох, эрүүл мэндийн мэдээлэл өгөх 27 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 328 иргэнийг хамруулав. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг тогтмолжуулах, чанарыг сайжруулах зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс Нийгмийн эрүүл мэндийн эмчээр Г.Болдыг томилон ажиллуулж байна. Эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл хүргэхээр дүүрэг болон ЭМТ-ийн вэб сайт, цахим хуудаст 34 төрлийн 573 мэдээлэл, зөвлөмжийг байршуулж түгээсэн ба хандалт 9856 байна.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| | | | | | 2024 | 250 | Сургалтад хамрагдагсад | тоо | 300 | 328 | | | |
| **Биеийн тамир** | | | | | | | | | | | | | |
| 2.2 Иргэдийг нийтийн биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана. | | | | | | | | | | | | | |
| 22 | 2.2.1 | Иргэдийг нийтийн биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана. | Биеийн тамир, спортын хороо | - | 2024 | 83 | Дугуйлан секцэд хамрагдагсад | тоо | 100 | 4250 | - | БТСХ нь иргэдийг биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлж 6 ААНБ-тай гэрээ байгуулж 7 хоног бүр 2 цаг спорт заалаар үйлчилж байна. "Дасгал хийж хамтдаа хөгжье", "Ажлын байрны дасгал", "Эрүүл Монгол хүн", "Өглөөний дасгал" зэрэг 5 аян өрнүүлж давхардсан тоогоор 71 байгууллагын 4250 ажилтан, албан хаагч, иргэд оролцов. | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дүүргийн төсөв | 2024 | 15 | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 20 | 27 | 43,3 | Мөн мэргэжлийн спортын 12 холбоотой хамтран "Өвлийн өдөрлөг-Мөсний сурын харваа", "Багахангай лиг-2025", "Багахангай Марафон-2025" Улсын аварга шалгаруулах тэмцээн, "Гар дээр суниалтын аварга шалгаруулах тэмцээн", Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн нэрэмжит "Мини волейбол"-ын U11, U12 насны тэмцээн, Уран хөдөлгөөнт гимнастик, " Багахангай-2025" 100 км-ын алхалт зэрэг 27 тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 6778 тамирчин оролцож 43,3 сая төгрөг зарцуулав. Хэрэгжилтийн хувь 100 | |
| 23 | 2.2.2 | Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | Биеийн тамир, спортын хороо | Дүүргийн төсөв | 2024 | 4 | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 6 | 8 | 9,4 | Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг нь Сагсан бөмбөг, Волейбол, Үндэсний шагайн харваа, Чөлөөт бөх, Таеквондо гэсэн 5 төрлөөр хичээллэж байгаа ба давхардсан тоогоор 140 өсвөрийн тамирчид хамрагдаж байна. Таеквондо, Чөлөөт бөхийн 2025 оны Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон 2 дасгалжуулагч, 10 тамирчныг "Онцгой амжилт гаргасан багш, сурагчдыг шагнаж урамшуулах журам"-ын дагуу урамшуулав. Үндэсний их баяр наадмаар өсвөрийн шагайн харваанд түрүүлсэн баг, багш нарт хүндэтгэл үзүүлэх "Бахархал-Хүндэтгэл" арга хэмжээг зохион байгуулав. Дэлхийн аварга шалгаруулах Таеквондо, Чөлөөт бөхийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон 3 тамирчинд 9,4 сая төгрөг зарцуулав. Дүүргээс анхны дэлхийн хүрэл медалтан тодров. Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| | | | | | 2024 | 100 | Өсвөрийн шигшээ багийн тамирчид | тоо | 110 | 140 | | | |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 24 | 2.2.3 | "Спорт цогцолбор"-ын барилгыг ашиглалтад хүлээн авч, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана. | Биеийн тамир, спортын хороо | Дүүргийн төсөв | - | - | Тоног төхөөрөмжийн төрөл | тоо | 6 | 36 | 20,0 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж байгаа спорт заалны барилгыг "Алтайн шарга говь" ХХК 2022 оноос эхлэн одоог хүртэл барьж байна.<br>Тус барилгын ажлыг эрчимжүүлэхээр гүйцэтгэгч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай дүүргийн удирдлагууд 3 удаагийн уулзалт, Барилгын хөгжлийн төвийн инженерүүдтэй тогтмол холбогдож санал солилцож байгаагаас гадна ажлыг эрчимжүүлэх, ашиглалтад хүлээн авах тухай Засаг даргын 2025 оны 01/490 тоот албан бичгийг ССАЖЗЯам, БТСУХороо, Алтайн шарга говь ХХК-д хүргүүлэв.<br>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 20,0 сая төгрөгийн өртөг бүхий 36 нэр төрлийн шаардлагатай техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнээр хангав<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 25 | 2.2.5 | Иргэдэд үйлчлэх биеийн тамир, спортын стандартын шаардлага хангасан заал, талбайг нэмэгдүүлнэ. | Биеийн тамир, спортын хороо | НОНХС | 2024 | 5 | Стандартын шаардлага хангасан заал талбай | тоо | 1 | 1 | 113,1 | Дүүргийн хэмжээнд БТСХорооны 1, ЕБС-ийн 2 нийт 3 заал, Сагсан бөмбөгийн 3х3 талбай 2, сагсан бөмбөг болон волейболын 5 талбайг ашиглаж байна. Дүүргийн 2 дугаар хорооны "Спорт заал"-ны барилгын ажил дууссан ба хүлээн авах улсын комисс одоогоор ажиллаагүй байна.<br>НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын 94 дүгээр сургуулийн спорт заалны шал, дээврийн засварыг 113,1 сая төгрөгөөр засварлав.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| Боловсрол | | | | | | | | | | | | | |
| 2.3 Хүүхэд бүр чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлж, боловсролын байгууллагыг мэргэжлийн боловсон хүчнээр хангана. | | | | | | | | | | | | | |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | 2.3.1 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт засвар үйлчилгээ хийж хүртээмжийг нэмэгдүүлнэ. | ЕБС, СӨББ-ууд | НОНХС | - | - | Засварын ажлын гүйцэтгэл | хувь | 90 | 100 | 433,1 | Боловсролын байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулахад энэ онд 825,0 сая төгрөг зарцуулав. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 91 дүгээр сургуулийн 640 хүүхдийн суудалтай барилгын зураг төсвийг 159,3 сая төгрөгөөр хийлгэсэн бол боловсролын байгууллагуудад 20 ширхэг 112,0 сая төгрөгийн ухаалаг самбар нийлүүлэх ажлыг "Голден хоул" ХХК гүйцэтгэв. Ерөнхий боловсролын 91, 94 дүгээр сургуульд нийслэлийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 433,1 сая төгрөгийн агааржуулалт болон дотор засвар, сургуулийн дээвэр, спорт заалны шал засварлах ажлыг "БЭЗТ" констракшн ХХК, "Айр вектер" ХХК гүйцэтгэв. Өвөлжилтийн бэлтгэл байдлын хүрээнд 94 дүгээр сургуулийн уурын зуухыг шинэчлэх ажлыг 119,0 сая төгрөгөөр АОММ ХХК гүйцэтгэв.<br>Дүүргийн Засаг 2025 оны А/47 дугаар захирамжаар "Орчны аюулгүй байдлыг хангах, үзлэг шалгалт зохион байгуулах" ажлын дэд хэсгийг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 3 удаа хяналт шалгалт зохион байгуулж нийт 90 зөрчил үүнээс боловсролын байгууллагад 34 зөрчлийг илрүүлсэн бөгөөд 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар зөрчлийг бүрэн арилгаад байна. Одоогоор СӨБ-32 камер, 17 гэрэлтүүлэг, ЕБС- 27 ширхэг камер, 19 ширхэг гэрэлтүүлэгтэй байна.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | 2.3.2 | Багшийн ур чадварын түвшинг дээшлүүлнэ. | ЕБС, СӨББ-ууд | - | 2024 | 129 | Сургалтад хамрагдсан багш | тоо | 100 | 177 | 4,8 | 2024-2025 оны хичээлийн жилд 1,5,10 дахь жилдээ ажиллаж байгаа 9 багш үндсэн сургалтад хамрагдсан бол 2025-2026 оны хичээлийн жилд 20 багш хамрагдсан байна.<br>Багшийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "Суралцагчид боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн", "Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих", "Удирдлагын манлайлал менежмент", "Сургалтын орчин бүрдүүлэлт" зэрэг багшийн ур чадвар дээшлүүлэх танхимын сургалтад 111, цахим сургалтад 34 багш хамрагдав. Солонгос улсад зохион байгуулагдсан туршлага судлах, багшийг хөгжүүлэх, сургалтын үйл ажиллагаанд 44 дүгээр цэцэрлэгийн 2 багшийг хамруулж 3,1 сая, Япон улсад зохион байгуулагдсан "JALT-2025" чуулга уулзалтад дүүргийн 94-р сургуулийн Англи хэлний багшийг хамруулж 1,7 төгрөгийг тус тус зарцуулав.<br>2024-2025 оны СӨББ-ын багшийн гүйцэтгэлийн үнэлгээ 04 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулагдаж төрийн өмчийн 2 цэцэрлэгийн 8 багш, 8 бүлгийн 136 хүүхэд хамрагдсанаас 8 багш 1-3 дугаар түвшинд, 207 дугаар цэцэрлэг 1 дүгээр түвшинд үнэлэгдэн урамшуулалд хамрагдав. СӨББ-уудын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж 96,3 хувь байна.<br>ЕБС-ийн гүйцэтгэлийн үнэлгээ 05 дугаар сарын 12-23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж төрийн өмчийн 2 сургуулийн 34 багш, 34 бүлгийн 806 сурагч хамрагдсанаас 1 дүгээр түвшинд 13 багш үнэлэгдэн, байгууллагын үнэлгээгээр 91, 94 дүгээр сургууль 5 дугаар түвшинд байна. ЕБС-ийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 84,3 хувь<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 28 | 2.3.3 | Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана. | ЕБС, СӨББ-ууд | Дүүргийн төсөв | 2024 | 12 | Тоног төхөөрөмж | тоо | 20 | 20 | 113,6 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын байгууллагуудад 20 ширхэг 112,0 сая төгрөгийн ухаалаг самбар нийлүүлэх ажлыг "Голден хоул" ХХК гүйцэтгэв.<br>Ялгаатай хэрэгцээт хүүхдийн сурч хөгжих, бие даан амьдрах чадвар олгоход хүртээмжтэй, таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2025 оны А/73 дугаар захирамжаар 1,6 сая төгрөгийн өртөөр Насан туршийн суралцахуйн төвийн танхимыг тохижуулж сургалтын хэрэглэгдэхүүнээр хангав.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | 2.3.5 | Ялгаатай хэрэгцээт хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулна. | ЕБС, СӨББ-ууд | - | 2024 | 11 | Боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхэд | тоо | 12 | 28 | - | Дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй нийт 28 хүүхдийн 19 нь сургууль, 9 нь цэцэрлэгийн насны хүүхэд бүртгэлтэй байна. 2025-2026 оны хичээлийн жилд 91, 94 дүгээр сургуульд ялгаатай хэрэгцээт боловсрол шаардлагатай нийт 12 сурагч, 44 дүгээр цэцэрлэгт 2, 207-р цэцэрлэгт 3 хүүхэд ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллэв.<br>Тэгш хамран сургах, багш нарын сурагчидтай ажиллах арга зүйн чадварыг дээшлүүлэх зорилгоор "АДИНА" төслийн модуль сургалтад 10 багшийг хамруулав. 2025-2026 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байгаа СӨББ-ын багш, багшийн туслах, ЕБС-ийн нийт 11 багшид БСШУС-ын сайдын 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/296 дугаар "Заавар батлах тухай" тушаалыг үндэслэн цалингийн 10%-иар нэмэгдэл хөлс олгов.<br>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/37 дугаар захирамжаар байгуулагдсан "Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-ийн хурлыг 1 удаа зохион байгуулж боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа 5 настай 2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх асран хамгаалагчтай уулзалт ярилцлага хийж 207 дугаар цэцэрлэгт 200 багц цагийн хичээлд хамруулахаар шийдвэрлэв.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 30 | 2.3.6 | "Сүү", "Үдийн хоол" хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | ЕБС, СӨББ-ууд | Дүүргийн төсөв | 2024 | 700 | Хөтөлбөрт хамрагдсан суралцагчид | тоо | 710 | 901 | 31,1 | 2025-2026 оны хичээлийн жилд төрийн өмчийн 2 цэцэрлэг "Налайх хангамж" нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүн ашиглаж байна.<br>Нийслэлийн ерөнхий боловсролын 91, 94 дүгээр сургуулиуд "Үдийн хоол" хөтөлбөрт хэрэглэгдэх хүнсний бүтээгдэхүүнийг "Төрийн худалдан авах цахим дэлгүүр", Сүү ХК-ны гэрээт борлуулагч ЭБББ, Тайхар хайрхан дэлгүүрээс худалдан авалт хийж лабораторийн шинжилгээ, савлагаа үйлдвэрлэсэн оныг шалгаж, хяналт тавин ажиллаж байна. ЕБС-ийн Үдийн хоол хөтөлбөрт 436 сурагч, СӨББ-д 276 суралцагч хамрагдаж байна.<br>"Сүү" хөтөлбөрт дүүргээс 31,1 сая төгрөг төсөвлөсөн ба 2025 оны 09 дүгээр сараас эхлэн 7 хоногт 3 удаа 200г сүү өгөхөөс 2 өдрийг нь дүүргийн төсвөөс 1 өдрийг нь эцэг эх асран хамгаалагчаас гаргуулан "Сүү" ХК-ны 200 гр сүүг 1-12-р ангийн нийт 901 сурагчдад өгч байна.<br>Сурагчдын 7 хоногийн 1 өдрийн сүүний 11,3 сая төгрөг эцэг эх асран хамгаалагчдаас цугласан байна.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | 2.3.7 | "Насан туршийн суралцахуйн төв"-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулна. | Насан туршийн суралцахуйн төв | Дүүргийн төсөв | - | - | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 3 | 29 | 38,6 | Дүүргийн Насан туршийн суралцахуйн төв нь 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс бие даасан төв болон үйл ажиллагаагаа явуулж эхлэв. Насан туршийн суралцахуйн төвд 26 сурагч боловсрол нөхөн эзэмших чиглэлээр суралцаж байгаа ба үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 2 байна. Насан туршийн боловсролын багш нар ажил мэргэжлийн баримжаа олгох, мэргэжил сонголт, хувь хүний хөгжил зэрэг 12 чиглэлээр давхардсан тоогоор 135 удаа сургалт зохион байгуулж 3973 хүүхэд, иргэнийг хамруулаад байна.<br>Мөн 17 удаагийн нөлөөллийн ажил арга хэмжээ зохион байгуулж 437 иргэнд 3 төрлийн гарын авлага , зөвлөмж хүргэлээ.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| Нийгмийн халамж | | | | | | | | | | | | | |
| 2.4.Дүүргийн хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ. | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 62 | | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж, байнгын арчлалт хамгаалалт хийх замаар бүрэн ургалтыг дэмжинэ. | ГНБ ОНӨААТҮГ | Дүүргийн төсөв | 2024 | 10250 | Тарьсан мод | тоо | 10500 | 7179 | 6,7 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 35 аж ахуйн нэгж, байгууллага, 424 өрх агч, голт бор, монос, улиас гэсэн 4 нэр төрлийн 7179 ширхэг мод тарив. Тус ажилд 53,7 сая төгрөг зарцуулав.<br>Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад мод бут тарьж суулгах, усалгаа, арчилгааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилласан байна.<br>Хэрэгжилтийн хувь 68,3 | 68 |
| 63 | 4.1.2 | Дүүргийн 2 дугаар хорооны "Хангай хотхон"-ы баруун талын ногоон байгууламжийг арчлан хамгаалж, "Өрх бүр-Нэг мод" аяныг үргэлжлүүлнэ. | ГНБ ОНӨААТҮГ | Дүүргийн төсөв | 2024 | 2555 | Тарьсан мод | тоо | 3000 | 1220 | 3,0 | Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ нь 2 дугаар хорооны "Хангай хотхон"-ын баруун талын 3300м$^2$ талбайн ногоон байгууламжийг арчлах, түүвэр цэвэрлэгээ хийх, хайс хашааг засварлах ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэв. Тус байршилд 120м$^2$ талбайд зүлэг, 210 ш навчит мод, 28 ш бут сөөг, нөхөн тарилтаар 50 ш улиас мод тарив.<br>Дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор "Нэг өрх-Нэг мод" аяныг өрнүүлж 1 дүгээр хорооны нэгдсэн ногооны талбай, 2 дугаар хорооны Цагдаагийн постны зүүн талд авто зам дагуу шинээр хашаа барьж, 1000ш агч, 220ш гоёлын мод тарьж, тус ажилд 9,5 сая төгрөг зарцуулав.<br>Хэрэгжилтийн хувь 40,7 | 41 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 64 | 4.1.3 | Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, иргэдэд дэмжлэг үзүүлнэ. | ЗДТГ | - | 2024 | 48 | Тариалан эрхлэгчид | тоо | 50 | 61 | - | Хүнсний нарийн ногоо тариалах хүсэлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэхээр 2 төрлийн (лууван, хүрэн манжин) хүнсний ногооны үрийг 1, 2 дугаар хорооны нийт 61 иргэнд олгов.<br>Тус онд дүүргийн хэмжээнд 2 га талбайд 20 өрх төмс, хүнсний ногоо тариалсан. Үүнээс 4 нэр төрлийн хүлэмжний ногоог (урт огурци, улаан лооль, чинжүү, бууцай) 9 өрх өрхийн хэрэгцээнд 80 мкв талбайд тарьж, 134 кг ургац хураасан.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 65 | 4.1.6 | Бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлох явцад эвдэгдсэн газрын нөхөн сэргээлт хийнэ. | БТ ОНӨААТҮГ | Нийслэлийн төсөв | 2024 | 2,5 | Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ | га | 3,0 | 2,1 | 100,0 | Тус ажлын хүрээнд 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн 2 байршилд нөхөн сэргээлтийн ажлыг 100,0 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулж, ажлын явц 70 хувьтай байна.<br>Хэрэгжилтийн хувь 70 | 70 |
| **Орчны аюулгүй байдал** | | | | | | | | | | | | | |
| 4.2 Иргэдийн амьдрах орчныг сайжруулан, орчны болон хөрсний бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангана. | | | | | | | | | | | | | |
| 66 | 4.2.1 | Орчны стандартыг мөрдүүлэн аюулгүй орчинг бүрдүүлж, хяналтыг сайжруулна. | ЗДТГ | - | 2024 | 90 | Хяналт шалгалтаар бууруулсан зөрчил | хувь | 90 | 96,6 | - | Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237, дүүргийн Засаг даргын А/47 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус онд 1, 2 дугаар хороонд Орчны аюулгүй байдлыг хангах, үзлэг шалгалтыг 4 удаа зохион байгуулав.<br>Хяналт шалгалтаар нийт 90 зөрчил илэрснийг арилгуулахаар холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгч 87 зөрчлийг арилгуулан 96,6 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Хэрэгжилтийн хувь 96,6 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 67 | 4.2.3 | Усны шинэ эх үүсвэрийг тусгай хамгаалалтад авч, хашаажуулах ажлын төсвийг боловсруулна. | ЗДТГ | - | - | - | Хүргүүлсэн сана | тоо | 1 | 1 | - | Засаг даргын Тамгын газар нь Багахангай Ус суваг ашиглалтын товчоотой хамтран ундны эх үүсвэрийн 3 худгийг хашаажуулахад шаардагдах төсвийг боловсруулж, Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газарт хүргүүлэв.<br>Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газар нь мэргэжлийн төсөвчингөөр төсвийг хянуулж, холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.<br>Тус ажилд 555,0 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.<br>Хэрэгжилтийн хувь 90 | 100 |
| ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | | | | | | | |
| Засаглалын шинэчлэлт | | | | | | | | | | | | | |
| 5.1 Иргэн төвтэй, авлигаас ангид, цахимжсан, ил тод, нээлттэй, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлсэн дүүрэг болно. | | | | | | | | | | | | | |
| 68 | 5.1.1 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавина. | ДАА | - | 2024 | 84,7 | Шилэн дансны хуулийн хэрэгжилт | хувь | 88,3 | 92,1 | - | Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах 15 байгууллагын 2025 оны 1-р улирлын байдлаарх шилэн дансны мэдээллийн үйл ажиллагаанд нийцлийн аудит хийж, "САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ" дүгнэлтийг өгч, хэрэгжилт 86.7%-тай байна.<br>2025 оны 2-р улирлын байдлаарх шилэн дансны мэдээллийн үйл ажиллагаанд нийцлийн аудитыг хийж, "ХАНГАЛТТАЙ" дүгнэлтийг өгч, хэрэгжилт 98.6%-тай байна.<br>Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах 15 байгууллага болон нэмэлтээр Эрүүл мэндийн төв, Насан туршийн суралцахуйн төвийн 2025 оны 3-р улирлын байдлаарх шилэн дансны мэдээллийн үйл ажиллагаанд нийцлийн аудитыг хийж "ХАНГАЛТТАЙ" дүгнэлтийг өгч, хэрэгжилт 92.1%-тэй байна.<br>Хэрэгжилтийн хувь 92,1 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 69 | 5.1.2 | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлж, хороодоос иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Хороод | - | 2024 | 76 | Цахимаар үйлчилгээ авсан иргэд | тоо | 80 | 8460 | - | ХХҮХ нь: цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр E-halamj.mn системээр 13 төрлийн 30 үйлчилгээг үзүүлж, 4,223 иргэнийг хамруулж тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид 3.4 тэрбум төгрөг зарцуулсан.Мөн E-job системээр 326 иргэнд цахим заавар, мэдээллийг хороодын танхим, явуулын хэлбэрээр хүргэж, 398 иргэний мэдээллийг шинэчилж, ажил олгогчдод зориулсан цахим сургалтын материалыг 19 аж ахуйн нэгжид хүргүүлсэн.<br>НДГ нь: 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 1005 даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ, 69 ажил олгогч, 84 сайн дурын даатгуулагчдад цахимаар үйлчилгээ үзүүлсэн байна.<br>УБХ нь: Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлж, хороодоос иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр нийт 2415 иргэнд цахим үйлчилгээг үзүүлсэн.<br>Хороод нь: Хур-Дан цэгээр дамжуулан нийт 93 иргэнд төрийн цахим үйлчилгээг үзүүлэн ажиллалаа.<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Засаг даргын Тамгын газартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилгоор тусгай хэрэгцээт төрийн цахим үйлчилгээний КИОСК машиныг 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн Засаг даргын Тамгын газарт байршуулж төрийн үйлчилгээг нэг дороос үзүүлж тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 72 төрлийн үйлчилгээг 56 иргэн аваад байна.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 70 | 5.1.3 | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлнэ. | ЗДТГ | Дүүргийн төсөв | - | - | Төлөвлөгөөний хэрэгжилт | хувь | 80 | 90 | 180,0 | 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус III хуралдаан хуралдаж Дүүргийн төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 11 арга хэмжээтэйгээр баталсан.<br>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын 2025 оны А/84 дугаар захирамжаар нийт 2 зорилго 12 арга хэмжээтэй батлан хэрэгжилтийг хангаж ажиллалаа.<br>Тус хөтөлбөрийн хүрээнд 12 арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд 1945 албан хаагчийг хамруулан 180 сая төгрөг зарцуулан ажиллалаа.<br>"Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг ДИТХ-ын 2025 оны А/20 дугаар тогтоолоор "90" хувийн хэрэгжилттэй "Үр дүнтэй" гэж үнэллээ.<br>Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутамд 1 удаа 6 сарын үндсэн цалинтай тэмцэх хэмжээний мөнгөн урамшууллыг нийт 4 албан хаагчдад 27,1 сая төгрөгийг олгосон.<br>Мөн төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиараар орон нутгийн нэмэгдэл олгох журмын дагуу нийт 312 албан хаагчдад 1,097 тэрбум төгрөгийн орон нутгийн нэмэгдэл олгон ажиллалаа.<br>Хэрэгжилтийн хувь 90 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 71 | 5.1.4 | Дүүргийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтын тогтолцоог бэхжүүлж, ур чадвар, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | ЗДТГ | - | 2024 | 500 | Сургалтад хамрагдсан албан хаагчид | тоо | 600 | 1540 | - | Төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшил ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтуудыг үе шаттай зохион байгуулан нийслэл, яам, агентлаг, удирдлагын академи, хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран жилийн эцсийн байдлаар нийт давхардсан тоогоор 15 аж ахуйн нэгж байгууллагын 1540 албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэн ажиллалаа.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 72 | 5.1.5 | Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлнэ. | ЗДТГ | Дүүргийн төсөв | 2024 | 90 | Төлөвлөгөөний хэрэгжилт | хувь | 95 | 100 | 1,0 | Дүүргийн Архивын 2025 оны ажлын төлөвлөгөөг 10 бүлэг, 25 заалттайгаар батлуулан, жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг 100 хувь хангаж ажиллалаа. 2025 оны жилийн эцсийн байдлаар 706 баримтыг түр хугацаагаар ашиглуулж, 78 лавлагаа хуулбар хувь олгон тоо бүртгэлийн баримт бичгүүдийг бүрэн хөтлөн явуулав. Дүүргийн хэмжээнд нийт 8363, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 0, байгууллагаар бүртгэгдсэн 571 системээр бүртгэгдсэн 7797, хариутай 1776, хугацаандаа хаасан 1716, хугацаа хэтэрч хаасан 10, судалж байгаа 177, хугацаа дөхсөн 7, хугацаа сунгуулсан 10, шийдвэрлэлтийн хувь 99,91 хувьтай, албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж 4,2 байна. Дүүргийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлыг 4 удаа зохион байгуулж, 6 асуудлыг хэлэлцэн баталсан. Дүүргийн Засаг даргын 2025 оны А/112 дугаар захирамжийн дагуу дүүргийн Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг 10 дугаар сарын 14-23-ны өдрийн хооронд төрийн 23 байгууллагад зохион байгуулан, илэрсэн зөрчил, дутагдлыг илтгэх хуудсаар баталгаажуулж, Нийслэлийн архивын газарт хүргүүлэн, зөрчил дутагдлыг арилгах зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Архивын хэлтсээс харьяа байгууллагуудын албан хаагчдад танхимаар 2, цахимаар 2 удаагийн сургалт зохион байгуулан давхардсан тоогоор 52 байгууллагын 156 албан хаагчдыг хамруулав.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 73 | 5.1.6 | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэнэ. | ЗДТГ | - | 2024 | 90 | Шийдвэрлэлтийн дундаж | хувь | 95 | 100 | - | 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар иргэдээс дүүргийн нутгийн захиргааны 21 байгууллагад нийт 322 өргөдөл ирснээс 322 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100%-тай, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 19 цаг 1 минут байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөлд хууль зүйн үндэслэлийг тусган, 32 өргөдлийн хариуг иргэнд албан бичгээр, 228 өргөдлийн хариуг иргэнд биечлэн хүргэж, 62 өргөдлийн хариуг утсаар өгч ажиллалаа. Иргэний талд шийдвэрлэсэн 258 өргөдөл, боломжгүй хариу өгсөн 63 өргөдөл байна.<br>Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад 11 байгууллага 27 зөрчил гаргасан байна. Зөрчил гаргасан 11 байгууллагын 14 албан хаагчаас тайлбар мэдээллийг бичгээр авч, НЗДТГ-т 7 хоног бүр хүргэн, цаашид өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэхгүй байх, шийдвэрлэлтийн явцад зөрчил гаргахгүй байхад анхаарч ажиллахыг үүрэг чиглэл болгов.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 74 | 5.1.7 | Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлнэ | ЗДТГ | - | 2024 | | Сурталчилсан материал | төрөл/ тоо | 10/200 | 12/ 482 | - | "Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллага, ААНБ-ын хүлээх үүрэг, хориглох зүйл", "Авлигын тухай болон албан үүргээ хэндлэнгээс нөлөөлөх байдлыг мэдэгдэх", "Нийтийн албан тушаалтан, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалтны тухай ойлголт, анхаарах асуудал" 3 төрлийн гарын авлага бэлтгэн 34ш тарааж, "Авлигын тухай | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| | | | | | | | Зохион байгуулах сургалт | тоо/ хүн | 3/150 | 5/ 202 | - | мэдэгдэх", "Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх" тухай 2 төрлийн видео контент, "Үгүй гэж хэлээд, зөвийг бүтээе" постер бэлтгэн дүүргийн bagakhangai.ub.gov.mn веб сайт, байгууллагын фейсбүүк хуудсуудаар сурталчлан ажиллалаа.<br>Мөн Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах 9 төрлийн гарын авлага 24ш, плакат 138ш, стейкэр 286 ш иргэдэд тарааж зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллав.<br>Авлигатай тэмцэх газартай хамтран ХАСХОМ, ХАСУМ-ын цахим сургалт 4, "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн тухай ойлголт" цахим сургалт 1 удаа зохион байгуулан 7 ЭБАТ, 54 ХАСХОМ гаргах албан тушаалтан 141 төрийн болон үйлчилгээний албан хаагчдыг хамрууллаа.<br>Хэрэгжилтийн хувь 100 | |
| 75 | 5.1.8 | Эрх зүйн сургалт сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлэн, нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулна. | ЗДТГ | - | 2024 | -/- | Зохион байгуулах сургалт | тоо/ хүн | 28/ 700 | 26/ 946 | - | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/60 дугаар захирамжаар Дүүргийн Хууль, эрх зүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх 25 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зохион байгуулах нөлөөллийн арга хэмжээ | Тоо/хүн | 3/ 72 | 8/ 103 | - | ажиллаж байна.<br>Тус ажлын хүрээнд холбогдох дээд шатны байгууллага болон дүүргийн ААНБ-тай хамтран танхимын сургалт 21, цахим сургалт 5 удаа зохион байгуулан нийт 946 иргэд, албан хаагчдыг хамруулан эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна.<br>Налайх, Багахангай дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхтэй хамтран эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ 2, Багахангай, Налайх дүүргийн эрүү, иргэний тойргийн шүүх, Налайх, Багахангай дэх ШШГХ уулзалт 2, Хуулийн салбарын "Нээлттэй хаалганы" өдөрлөг арга хэмжээг 2, Налайх, Багахангай дэх ШШГХ хамтран Нийтэд тустай ажил 2 удаа зохион байгуулан 103 иргэн, албан тушаалтан хамруулав.<br>Хэрэгжилтийн хувь 100 | |
| 76 | | Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж, үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчилд зөвлөмж өгнө. | ДАА | - | 2024 | 9 | Хяналт шалгалт, дотоод аудит | тоо | 9 | 25 | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нийцлийн аудитыг 17 байгууллагад, гүйцэтгэлийн 6 аудит, санхүүгийн хяналт шалгалт 2 удаа тус тус хийж, 15 зөрчил дутагдал илрүүлэн 15 зөвлөмж өгч ажиллалаа.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 77 | 5.1.9 | Гадаадын улс орнуудтай хамтарсан арга хэмжээг зохион байгуулж, талуудын худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, аялал жуулчлал, хүмүүнлэг зэрэг бүхий л салбарын бодит хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | ЗДТГ | Дүүргийн төсөв | 2024 | 2 | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 3 | 3 | 7,5 | Дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх хүрээнд 2 улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулав. Үүнд: дүүргийн Засаг даргын Тамгын газар болон АНУ-ын Потомакийн их сургууль хооронд хамтын ажиллагааны гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулан ажиллав. БНСУ-ын Пусан хотын "Хүмэн Кейр Сервис" ХК-тай хамтын ажиллагаа тогтоон, 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.<br>Мөн БНСУ-ын Пусан хотын Кижан аймагтай хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар төслийг боловсруулан, тус аймгийн удирдлагуудтай 3 удаагийн уулзалтыг зохион байгуулаад байна.<br>Дүүргийн хэмжээнд нийт 20 байгууллагын давхардсан тоогоор 80 албан хаагч БНХАУ, БНСУ, Япон, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард улсад тус тус албан томилолтоор ажиллан, эрүүл мэнд, спорт, үйлдвэрлэл, хог хаягдал, онцгой байдлын салбарын үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцон, мэдлэг ур чадвараа дээшлүүлэв. Тус арга хэмжээнд дүүргийн зардлаас 155 сая төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн зардлаас 17,3 сая төгрөг зарцуулсан байна.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| Олон нийтийн аюулгүй байдлыг хангах | | | | | | | | | | | | | |
| 5.2 Иргэдийн амар тайван, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | | | | | |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 78 | 5.2.1 | Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийн дүн мэдээнд тулгуурлан хамтын ажиллагааг зохион байгуулна. | БХДЦХ | - | 2024 | 5 | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 10 | 17 | - | Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтсийн даргын 2025 оны А/01 дугаар тушаалаар "Дүн шинжилгээ, судалгааны багийн бүрэлдэхүүн"-ийг шинэчилсэн.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд "Урьдчилан сэргийлэх ажлын салбар төлөвлөгөө"-г 13 бүлэг, 84 ажил, арга хэмжээтэйгээр төлөвлөн, 98,6 хувьтай хэрэгжүүллээ.<br>Хамтын ажиллагааны хүрээнд 11 аж ахуйн нэгж, байгууллагыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан "Тарваган тахал", "Усттал-2025", "Хичээл эхэллээ", "Хяналт шалгалт, судалгаа" зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн нийт 17 арга хэмжээнүүдэд татан оролцуулж, хамтран ажиллалаа.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 79 | 5.2.2 | Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг "Теле камерын хяналтын дэд төв"-д холбож, гудамж, зам талбай, эмзэг цэгүүдийг камержуулна. | БХДЦХ | Дүүргийн төсөв | 2024 | 34 | "Багахангайн Теле камерын хяналтын дэд төв"-д холбосон камер | тоо | 90 | 85 | 48,0 | "Багахангайн Теле камерын хяналтын дэд төв" ОНӨААТҮГ нь 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс үйл ажиллагаагаа бүрэн эхлүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэрт 38 цэгийн 85 камерын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Ногоон бүс" төслийн хүрээнд дүүргийн хэмжээнд улсын төсвийн Хөделгөөнт: 13, | 85 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | - | | | 2024 | 11 | Камержуулсан цэг | тоо | 50 | 38 | | Чиглэлийн: 72, Дугаар таних: 2, Нийт камер: 85, Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны Хөдөлгөөнт: 8, Чиглэлийн: 164, Нийт камер: 172 теле хяналтын камерыг Camera.police.gov цахим санд шивж баталгаажуулсан.<br>Аж ахуйн нэгж, байгууллагын камерыг дэд төвтэй холбох ажлыг зохион байгуулахаар хуваарь гарган, аж ахуйн нэгж, байгууллагын гадна камерыг стандарт шаардлагад нийцсэн эсэхэд 2 удаа үзлэг хийж "Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага MNS 6423:2019 стандартыг бүрэн хангуулсан. Тус шаардлага хангасан 11 аж ахуйн нэгжийн стандарт шаардлагад нийцсэн 15 камерыг дэд төвтэй холбосон.<br>"Багахангайн Теле камерын хяналтын дэд төв"-д ГХЗУСТХуулийн 46,1-д заасны дагуу камержуулах ажилд 48,0 сая төгрөгийн төсвийг суулгаж "Дата камер лүүк" ХХК шалгарч 4 байршилд 24 камерыг суурилуулсан.<br>Хэрэгжилтийн хувь 85 | |
| 80 | 5.2.3 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулна. | БХДЦХ | Дүүргийн төсөв, орон нутгийн төсөв | 2024 | 12 | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 15 | 15 | 11,9 | Тус онд "Замын хөдөлгөөний цагаан толгой", "Ногоон гэрэл цагаан шугам", "Орон нутгийн зам хөдөлгөөний соёл", "Шугаман эргүүл хяналт шалгалт" зэрэг нэгдсэн арга хэмжээнүүдэд 11,9 сая төгрөг зарцуулсан. | 100 |
| | | | | | 2024 | 15000 | Илрүүлсэн зөрчил | тоо | 16000 | 17374 | - | Мөн "Мотоцикл ба Хамгаалах бүс", "Уусан бол бүү жолоод", "Аюултай ачаа, ачаа тээвэр", "Хяналт шалгалт", "Унадаг дугуй", "Хариулгагүй мал", "Өвлийн дугуй" зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн 15 арга хэмжээг зохион байгуулж, 11 дүгээр сарын байдлаар 17374 зөрчлийг илрүүлж, 673,7 сая төгрөгөөр торгуулийн арга хэмжээ оногдуулсан.<br>Хэрэгжилтийн хувь 100 | |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 81 | | Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах тэмдэг тэмдэглэгээний нэгдсэн тоог гаргаж, стандарт шаардлага хангаагүй тэмдэг тэмдэглэгээг сольж, шинээр байршуулна. | БХДЦХ | - | - | - | Шинээр байршуулсан тэмдэг тэмдэглэгээ | тоо | 2 | 2 | - | Хариуцсан нутаг дэвсгэрт байрлах тэмдэг, тэмдэглэгээнд энэ оны 05 дугаар сард нэгдсэн тооллого зохион байгуулахад 312 тэмдэг, 289 $м^2$ тэмдэглэгээ тоологдсон ба стандарт шаардлага хангаагүй 2 тэмдгийг сольж, 2 тэмдгийг нэмж байршуулсан.<br>Дүүргийн гудамж, талбай болон олон нийтийн газарт үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд гэмт хэрэг, зөрчилд судалгаа хийж гэр хорооллын гудамж, сургууль орчмын бүсэд 66 ширхэг гэрэлтүүлгийг нэмж байршуулах судалгааг гарган Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-т хүргүүлсэн.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа | | | | | | | | | | | | | |
| 5.3 Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлж, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | | | | | | | | |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 82 | 5.3.1 | Онцгой байдлын байгууллагуудын "Нэгдсэн бэлтгэл сургалтын төв"-ийг барьж байгуулна. | Гүйцэтгэгч ХХК | Улсын төсөв | 2024 | 30 | Барилгын ажлын явц | хувь | 50 | 15 | 637,9 | Дүүргийн Онцгой байдал, Цагдаа, Цэргийн штабын бие бүрэлдэхүүнд алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийг хангах, албаны болон хувийн бэлтгэл бэлэн байдлыг сайжруулах, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд дадлага, сургалтын талбайн зардлын тооцооллыг гарган, 2022 онд зураг, төсвийг "Стийл проект" ХХК-иар гүйцэтгүүлсэн.<br>Мөн газар эзэмших захирамж, гэрээ, кадастрын зургийг нийслэлийн 2024 оны газрын дахин төлөвлөлтийн төлөвлөгөөнд тусгуулсан.<br>Бие бүрэлдэхүүний дадлага, сургалт хийх талбайн (дугаар-ОБЕГ/20240101002) нээлттэй тендер шалгаруулалтыг 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр зарлаж, гүйцэтгэгчээр "Энх тэргүүн констракшн" ХХК шалгарсан.<br>Ажлын гүйцэтгэлд зориулж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 637,9 сая төгрөгийн санхүүжилтийг 2024 онд шийдвэрлэсний дагуу талбайг хашаажуулсан.<br>Хэрэгжилтийн хувь 30 | 30 |
| 83 | 5.3.2 | Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийнэ. | ОБХ | Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгө | - | - | Эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх хороод | тоо | 2 | (хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй) | 40,0 | Онцгой байдлын хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хороо тус бүрээр хийхээр төлөвлөсөн ба дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс холбогдох санхүүжилт татагдсан тул ажлын гүйцэтгэлийг 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.<br>Хэрэгжилтийн хувь (хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй) | - |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 84 | 5.3.3 | Нийтийн зориулалттай орон сууц, олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бөх, тэсвэржилтийн төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргуулж, паспортжуулна. | ОБХ | Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгө | 2024 | 1 | Паспортжуулсан барилга | тоо | 2 | (хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй) | 16,0 | Онцгой байдлын хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орон сууцны 2 барилгад газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийхээр төлөвлөсөн ба дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс холбогдох санхүүжилт татагдсан тул ажлын гүйцэтгэлийг 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.<br>Хэрэгжилтийн хувь (хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй) | - |
| Батлан хамгаалах үйл ажиллагаа | | | | | | | | | | | | | |
| 5.4.Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг иргэдийн оролцоотой сурталчлан, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана | | | | | | | | | | | | | |
| 85 | 5.4.1 | Батлан хамгаалах хууль тогтоомж, холбогдох хөтөлбөрийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлнэ. | Цэргийн штаб | - | 2024 | 5 | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 5 | 6 | 8,0 | Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 104 жилийн ойн хүрээнд дүүргийн хэмжээнд 6 ажил, арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор ЕБС-ийн 500 гаруй сурагч, 12 аж ахуйн нэгж, байгууллагын 300 гаруй алба хаагчид болон иргэдийг хамрууллаа.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 86 | | Иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгох, цэргийн алба хаах хэлбэрүүдийг сурталчлан, иргэн цэргийн харилцааг бэхжүүлнэ. | Цэргийн штаб | - | 2024 | 12 | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 1 | 1 | - | Дүүргийн 1, 2 дугаар хороо, 4 аж ахуйн нэгж байгууллагад Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд 18-55 насны 105 иргэнд хяналт шалгалт явуулж, 19 иргэнд мөнгөн төлбөр тогтоосон.<br>Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 87 | 5.4.2 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг хангаж, дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгоно. | Цэргийн штаб | - | 2024 | 6 | Зохион байгуулсан сургалт | тоо | 2 | 1 | 0,6 | Хорооны Засаг дарга нарын Цэргийн бэлтгэл сургалтыг 05 дугаар сарын 01-нээс 03-ны өдрүүдэд зохион байгуулж, 22 албан хаагчдыг хамруулсан.<br>Хэрэгжилтийн хувь 50 | 50 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин: он | Суурь түвшин: түвшин | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн: Зорилтот түвшин | Үр дүн: Хүрсэн түвшин | Үр дүн: Төсвийн гүйцэтгэл (сая төг) | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 88 | | Сургалт бэлтгэлийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | Цэргийн штаб | - | 2024 | 12 | Зохион байгуулсан сургалт | хувь | 1 | 1 | - | "Бид эх орны ирээдүй" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, ЗХ-ий 014, 350, 337, 353 дугаар ангиудтай хамтран ажиллаж, дүүргийн ЕБС-ийн 500 гаруй суралцагчдыг хамруулсан. Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 89 | | Дайчилгаа, Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн материаллаг нөөцийг бүрдүүлж, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна. | Цэргийн штаб | - | 2024 | 5 | Бүрдүүлсэн нөөц | тоо | 4 | 5 | 0,5 | Орон нутгийн хамгаалалтын материаллаг баазыг дээшлүүлэхээр 5 ш богино долгионы гар станцыг авч нөөц бүрдүүлсэн. Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 92 | | Дүүргийн хэмжээнд батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэд, хүүхэд, залуучуудад сурталчилна. | Цэргийн штаб | - | 2024 | 100 | Арга хэмжээнд оролцсон иргэд, сурагчид | тоо | 120 | 429 | - | Нийслэлийн ерөнхий боловсролын 91, 94 дүгээр сургуулийн сурагчдад "Эх оронч Монголчууд" нэлттэй хичээлийг зохион байгуулж, нийт 429 сурагчдыг хамруулсан. Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 91 | 5.4.3 | "Дөл" цоцолбор тэмцээнийг зохион байгуулна. | Цэргийн штаб | Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгө | 2024 | 36 | Тэмцээнд оролцсон сурагчид | тоо | 40 | 48 | 3,6 | Дүүргийн аварга шалгаруулах "Дөл" тэмцээнд 3 баг (36 хүүхэд), Улсын аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл" цоцолбор тэмцээнд НЕБ-ын 91 дүгээр сургуулийн 1 баг (12 хүүхэд) тамирчид тус тус амжилттай оролцсон. Хэрэгжилтийн хувь 100 | 100 |
| 92 | | Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг дээшлүүлэх ажлыг дүүргийн хэмжээнд холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | Цэргийн штаб | - | 2024 | 22 | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан цэргийн насны залуучууд | тоо | 25 | 11 | - | 2025 оны 2 дугаар ээлжийн хугацаат цэргийн татлагаар ЗХЖШ-ын даргаас тогтоосон тоон даалгаврыг биелүүлсэн. Зэвсэгт хүчний Цэргийн төв эмнэлэгтэй хамтран Тайван цагт цэргийн албанд тэнцэхгүй дүүргийн иргэдийн үзлэгийг зохион байгуулж, 11 иргэнд эмчийн дүгнэлт гарсан. Хэрэгжилтийн хувь 50 | 44 |

| № | ДЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтын эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хяналт шинжилгээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| **Хяналт-шинжилгээний дундаж үнэлгээ** | | | | | | | | | | | | **90.7% "Үр дүнтэй"** | |

Нийт 92 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласнаас үр дүнтэй-76, үр дүн хүлээгдэж байгаа-6, үр дүн хангалтгүй-8, үр дүн гараагүй-0, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй-2 арга хэмжээ байна. Хяналт-шинжилгээний ерөнхий үнэлгээ 90.7 хувьтай "Үр дүнтэй" гэж үнэлэв.

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Н.БАТЦЭНГЭЛ

ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН
ТОГТООЛ ШИЙДВЭР, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ОДБАЯР